



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДАНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 11

Шарга

Г

Т

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ**:

1. Хог хаягдал ачих, тээвэрлэхэд айл өрх, иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагаас дагаж мөрдөх журамд тэргүүлэгчдээс гарсан саналыг тусган 1 дүгээр хавсралтаар, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх хураамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцон ажиллахыг сумын Засаг дарга /Д.Түмэнбаяр/. Байгаль орчны хяналтын улсын байцаагч /Г.Одгэрэл/ нарт даалгасугай.
3. Энэ журмыг дагаж мөрдөн хэрэгжүүлж ажиллахыг аж ахуйн нэгж, албан байгууллага, нийт иргэдэд уриалсугай.

ДАРГА
Ч.АЗБАЯР

60078



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 12

Шарга

Г Ажил дүгнэх тухай

Монгол Улсын Нийгмийн Халамжийн Тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ**:

1. Сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн 2013 онд хийсэн ажлыг Хангалттай гэж дүгнэсүгэй.
2. 2014 оны үйл ажиллагаандаа Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс гарсан саналыг тусгаж, жилийн төлөвлөгөө боловсруулж 4 дүгээр сард багтаан батлуулж ажиллахыг зөвлөлийн дарга /Т.Мөнхбаяр/, нарийн бичгийн дарга /Д.Ундрахбуян/ нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Ч.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.



00079



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 13

Шарга

Г Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ**:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж Хавсралтаар баталсугай.
2. Зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбогдуулан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн байгуулах тухай 2008 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 42 дугаар тогтоол, Нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2010 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 11 дүгээр тогтоолуудыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг удирдлага чиглэлээр хангаж ажиллахыг зөвлөлийн дарга /Ч.Азбаяр/, ажлын төлөвлөгөөний биелэлт, үр дүнг тайлагнаж ажиллахыг зөвлөлийн нарийн бичгийн дарга /Н.Зөнбилэг/-д даалгасугай.

ДАРГА Ч.АЗБАЯР



00000

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр сарын 11-ний
13 дугаар тогтоолын Хавсралт

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Ч.Азбаяр /Сумын ИТХ-ын дарга/
Нарийн бичгийн дарга: Н.Зөнбилэг /Хэсгийн төлөөлөгч/
Гишүүд: Э.Оюунбат /Цагдаа/
Д.Төмөрчедөр /Олон нийтийн байцаагч/
Д.Загдрагчаа /Сумын нийгмийн ажилтан/
У.Оюунчимэг /Боловсролын нийгмийн ажилтан/
Ж.Сосорбарам /СДЭМнэлгийн нийгмийн ажилтан/
Б.Цэдэндамба /Агарын заставын дарга/
Ч.Мөнхцэцэг /ИТХ-ын нарийн бичгийн дарга/
Ж.Жамбалсүрэн /1-р багийн засаг дарга/
Ж.Бумцэнд /2-р багийн засаг дарга/
О.Шадав /3-р багийн засаг дарга/
Б.Баасанчулуун /4-р багийн засаг дарга/
Г.Бадрал /5-р багийн засаг дарга/
Н.Алтанбаатар /6-р багийн засаг дарга/
Н.Батсайхан /"Цогт" дэлгүүр/
П.Оюунбат /"Тосон" дэлгүүр/
Д.Мөнхбат /"Оргил", дэлгүүр/
Д.Мөнх-Эрдэнэ /"Цагаан-Уул" дэлгүүр/
А.Лхагвадэмбэрэл /"Номин" дэлгүүр/
Ж.Алимаа /"Богд" дэлгүүр/
Б.Нямжав /"Агар" дэлгүүр/
М.Мөнхбаатар /"Урьхан" зоогийн газар/

ооо



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 14

Шарга

Г Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
хуралдаан зарлах, хэлэлцэх асуудал
төвлох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ**:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус хуралдааныг 2014 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 10⁰⁰ цагт Соёлын төвд хуралдуулсугай.
2. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр Хавсралт, хуралдааны бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг 2 дугаар Хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралдааны бэлтгэл ажлыг хангах, хуралдааны зар хүргэх ажлыг зохион байгуулахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Ч.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА Ч.АЗБАЯР



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр сарын 11-ний
14 дүгээр тогтоолын 1 дүгээр Хавсралт

**СУМЫН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
I ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД**

1. Сум хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр батлах тухай
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд өөрчлөлт оруулах тухай
3. Ахмадын байрыг "Галт-Дулаан" ОНӨААТҮ-ийн газарт шилжүүлэх тухай
4. Бэлчээр ашиглах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
5. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр сарын 11-ний
14 дүгээр тогтоолын Хавсралт

**ЦАГААН-УУЛ СУМЫН ИТХ-ЫН ЭЭЛЖИТ БУС I ХУРАЛДААНЫ
БЭЛТГЭЛ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажлууд	Хугацаа	Хариуцах эзэн	Хяналт тавих эзэн
1	Хуралдааны зар хүргэх, хуралдааны танхим бэлтгэх	2014.04.11-2014.04.25	ЗДТГ-ын даргын түр орлон гүйцэтгэгч Т.Лхамсүрэн, ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Мөнхцэцэг	ИТХ-ын дарга
2	Сум хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр батлах тухай	2014.04.11-2014.04.25	Засаг дарга Д.Түмэнбаяр	ИТХ-ын Тэргүүлэгчид
3	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд өөрчлөлт оруулах тухай	2014.04.11-2014.04.25	Төрийн сангийн төлөөлөгч Ш.Эрдэнэцэцэг	ИТХ-ын Тэргүүлэгчид
4	Ахмадын байрыг "Галт-Дулаан" ОНӨААТҮГазарт шилжүүлэх тухай	2014.04.11-2014.04.25	Засаг дарга Д.Түмэнбаяр	ИТХ-ын Тэргүүлэгчид
5	Бэлчээр ашиглах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	2014.04.11-2014.04.25	Багийн засаг дарга нар, БОХУБ Г.Одгэрэл	ИТХ-ын Тэргүүлэгчид
6	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай	2014.04.11-2014.04.25	БОТХБТасаг	ИТХ-ын Тэргүүлэгчид

ооо